

Улсын бүртгэлийн дугаар
Аравтын бүрэн
Ангиллын код

Нууцын зэрэглэл:Б
Төсөл гүйцэтгэх гэрээний дугаар
ШуСс-2019/59

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН**

**БНМАУ: СОЦИАЛИЗМ БА БУРХАНЫ
ШАШИН (1944-1990 ОН)**

**Суурь судалгааны төсөл
2019-2022**

**Төслийн гүйцэтгэгч:
Төслийн удирдагч:**

**Түүх, угсаатны зүйн хүрээлэн
Г.Мягмарсамбуу-доктор (Sc.D),
профессор Түүх, угсаатны зүйн
хүрээлэнгийн Ойрх үеийн судалгааны
салбарын ЭШТА**

**Санхүүжүүлэгч байгууллага:
Захиалагч байгууллага:
Тайлан өмчлөгч:**

**Шинжлэх ухаан технологийн сан
Боловсрол, шинжлэх ухааны яам
Түүх, угсаатны зүйн хүрээлэн
Монгол улс, 13330 Улаанбаатар хот,
БЗД, 13-р хороо, Энхтайваны өргөн
чөлөө. Утас:11-458305,
Цахим**

шуудан:history@mas.ac.mn

**УЛААНБААТАР
2023**

Реферат

Дэлхийн хоёрдугаар дайны дараа БНМАУ энхийн бүтээн байгуулалтад шилжиж, 1954 онд хуралдсан МАХН-ын XII их хурал “социализмыг дэлгэрэнгүй байгуулах”, 1961 онд хуралдсан МАХН-ын XIV их хурал социализм байгуулж дуусгах зорилтыг тус тус дэвшүүлснээр улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л бодлого, үйл ажиллагаа “социализм байгуулах”-д чиглэж, “социалист бүтээн байгуулалт”-ыг өрнүүлснээр Монгол улс хөгжил дэвшлийн шинэ шатанд гарчээ. Харин нийгмийн оюун санааны амьдрал хэт үзэл сурталжин, Марксизм-Ленинизмийг цорын ганц үнэн зөв сургаал хэмээн тунхаглаж, ард түмнийг коммунист үзлээр хүмүүжүүлэхэд онцгой анхаарч байв. Социалист үйлдвэрлэлийн харилцаа ялан социалист аж төрөх ёс хэвшин тогтож, Марксист-Ленинист үзэл суртал Монголын ард түмний үзэл санааны үндэс болсноор “хуучин нийгмийн үлдэгдэл” оршин байх нийгэм, эдийн засаг, оюун санааны үндэс устаж, өнгөрсөн үеийн хоцрогдлоос хөдөлмөрчдийг чөлөөлөх болно гэж үзэж байв. Нийгмийн ахуй, ухамсар дахь “хуучин нийгмийн хоцрогдол”-д шашны ухамсар багтаж байв. Тийм учраас нам, төрөөс шашны эсрэг тэмцлийг янз бүрийн хэлбэрээр, тасралтгүй, өргөн дайлайцтай явуулахыг зорьж байв. Гэхдээ өгүүлэн буй үед нам, төрөөс шашны талаар баримталж байсан бодлого, үйл ажиллагааг зөвхөн шашин шүтлэгийг хааж боох, ард түмнийг шашингүйн үзлээр хүмүүжүүлэхэд чиглэж, Монгол оронд шашны асуудал бүрэн хаалттай байсан хэмээн үзэж болохгүй юм. Социализмын үед шашин үгүйсгэгдэхийн зэрэгцээгээр ил болон далд хэлбэрээр бодитой оршин тогтнож, шашны харилцаа нь нийгмийн харилцаанд зохих байр суурийг эзэлсээр иржээ. Энэ асуудлыг цаашид олон талаас нь гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ шаардлага бидний өмнө тулгарч байгаа бөгөөд энэ шаардлагын үүднээс ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн 2019-2022 онд “БНМАУ: Социализм ба Бурхны шашин” (ШуСс_2019/59) сэдэвт суурь судалгааны төслийг хэрэгжүүлэв.

Энэхүү судалгааг явуулахдаа социализмын үеийн буддын шашин, сүм хийдийн асуудлыг дараах 2 үе шатанд хуваан авч үзэж судлав. Үүнд,

Нэгд: Улаанбаатар хотод “Мөргөлийн дуган”-ыг нээсэн 1944 оноос шашин шүтлэгийн эсрэг тэмцэл эрчимжсэн 1960 он хүртэлх үе,

Хоёрт: БНМАУ-д социализм байгуулж дуусгах зорилтыг дэвшүүлсэн 1960 оноос Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсан 1992 он хүртэлх үе.

Багагүй саад бэрхшээлтэй тулгарч байсан боловч социализмын жилүүдэд Монголын бурхны шашны эрдэм ухаан, түүх, өв соёл, зан заншил уламжлал-шинэчлэлийн замаар замнан, Монголын бурхны шашны сүм хийд, лам нарын нэр хүнд олон улсын тавцанд ихээхэн өссөн байна. Аливаа улс төрийн үзэл суртал нь тухайн ард түмний шашин соёлыг үгүйсгэж, ард түмний шүтэх бишрэх эрх чөлөөг бүрэн хаах боломжгүйг БНМАУ-ын “социалист байгуулалтын үе”-ийн шашны түүх нотлон харуулж байна. Ямарч үед төр засаг нь ард түмнийхээ хүсэл бодол, итгэл үнэмшил, сүсэг бишрэл, үндэсний шашин соёлдоо илүү хүндэтгэлтэй хандаж байх нь чухал юм. Ямарваа нэгэн улс төрийн үзэл суртал, эрх ашиг, зорилгыг үндэсний эрх ашиг, шашин соёлоос дээгүүр тавьж сэргэлдүүлэх аваас зорилгодоо үл хүрэх төдийгүй нөхөж баршгүй гарз хохирол амсдаг болохыг нам, төрөөс 1930-аад онд шашны талаар явуулсан бодлого, үйл ажиллагаанаас харж болно. Судалгааныхаа үр дүнд бид,

- Нам, төрийн бодлогод шашны асуудал томоохон байр суурийг эзэлж байсан бөгөөд социализмын үед шашин бодитой оршин тогтнож байсан,

- Улс төрийн хэлмэгдүүлэлтийн уршгаар мөхлийн ирмэгт тулж очоод байсан бурхны шашин соёлын дахин сэргэх үйл явц Улаанбаатар хотод Мөргөлийн дуган нээснээр эхэлж, 1980-аад оны сүүлч хүртэл тасралтгүй үргэлжилсэн,

- Социализмын жилүүдэд шашны гадаад харилцаа шинэ агуулга, чиглэлээр хөгжин гүнзгийрсэн,

- БНМАУ-ын Засгийн газар, МАХН-аас баримталж байсан шашны бодлогод ЗХУ-ын нөлөө их байсан гэсэн дүгнэлтүүдийг хийв.

Суурь судалгааны үр дүнгээр “БНМАУ: Социализм ба Буддизм” (1944-1992) нэгэн сэдэвт бүтээл, “БНМАУ: Социализм ба Бурхны шашин” (Аман түүх) бүтээл болон илтгэл, өгүүлэл 7-г бичиж хэвлүүлэв.

Түлхүүр үг: Социализм, бурхны шашин, Мөргөлийн дуган, шашингүйн үзэл, шашингүйн суртал нэвтрүүлэг, сүм хийд.

ГҮЙЦЭТГЭГЧИЙН НЭРИЙН ЖАГСААЛТ

1. Галиндэвийн Мягмарсамбуу, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, доктор (Ph.D), профессор (Нэгэн сэдэвт зохиол)
2. Нямдоржийн Мягмар, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, доктор (Ph.D) (Аман түүхийн бүтээл)
3. Ганбатын Цэрэнсугар, магистр (Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл)

ГАРЧИГ

Реферат.....	2-3
Гүйцэтгэгчийн нэрийн жагсаалт.....	4
Товчилсон үгийн жагсаалт.....	5
Удиртгал.....	6-12
Тайлангийн үндсэн хэсэг.....	13-17
Дүгнэлт.....	18
Номзүй.....	19-20
Хавсралт №1. Хэвлэгдсэн бүтээл.....	21
Хавсралт №2. Эрдэм шинжилгээний илтгэл.....	22-39
Хавсралт №3. Эрдэм шинжилгээний өгүүлэл.....	40-64

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БШУЯ-Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
БНМАУ-Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНЧУ-Бүгд Найрамдах Чех Улс
МУБИС-Монгол Улсын Боловсролын Их Сургууль
МУИС-Монгол Улсын Их Сургууль
МБШТ-Монголын Бурхан Шашинтны Төв
МҮИС-Монголын Үндэсний Их Сургууль
ТЕГ-Тагнуулын Ерөнхий Газар
ОУДС-Олон Улсын Дээд Сургууль
ОУМСХ-Олон Улсын Монгол Судлалын Холбоо
ОХУ-Оросын Холбооны Улс
ШДС-Шашны Дээд Сургууль
ШХЭЗ-Шашны хэрэг эрхлэх зөвлөл
ШУТС-Шинжлэх Ухаан Технологийн Сан
ШУА-Шинжлэх Ухааны Академи
ФСЭХ-Философи, Социологи Эрхийн Хүрээлэн

УДИРТГАЛ

Монгол Улсын БШУЯ-ны захиалга, ШУТС-ийн санхүүжилтээр “БНМАУ: Социализм ба бурхны шашин” (1944-1990 он) суурь судалгааны төслийг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнд 2019-2022 онд амжилттай гүйцэтгэв.

Сэдэвт ажлын зорилго нь өгүүлэн буй үед БНМАУ-ын төр, засгаас шашны талаар баримталсан бодлого, түүний үр дагавар болон тухайн үеийн нийгмийн ухамсрын төвшинд шашны эзэлж байсан байр суурь, гүйцэтгэсэн үүргийг түүх-шашин судлалын үүднээс нэгтгэн судлах замаар шинэ мэдлэг бүхий бүтээл туурвихад оршино. Үүний тулд дараах зорилтуудыг шийдвэрлэсэн болно. Үүнд:

А. Нам, төрөөс шашны талаар баримталж байсан бодлогыг нийгмийн ухамсрын төвшин дэх шашин шүтлэгийн байдалтай харьцуулан судалж, эерэг болон сөрөг үр дагавар, түүхэн сургамжийг тодорхойлох,

Б. БНМАУ-д үйл ажиллагаа явуулж байсан сүм хийд, лам нарын талаар Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн архивуудад баримт, гэрэл зураг, кино зургийн нарийвчилсан судалгаа явуулах,

В. Шашин, сүм хийд, лам нарын талаар аман түүхийн судалгаа явуулж судалгааны баазыг өргөжүүлэх.

Сэдэвт ажлын шинэлэг тал нь:

1. БНМАУ-ын шашин сүм хийдийн асуудлыг анх удаа олон талын эх сурвалжийг ашиглан, түүхэн зарчмыг удирдлага болгон цогц байдлаар авч үзэж, тал бүрээс нь судлан үнэлж дүгнэсэн,

2. Тухайн сэдвээр аман түүхийн судалгаа явуулснаас гадна холбогдох баримт, дуу, дүрс бичлэгийг хуулбарлан авах замаар судалгааны баазыг өргөжүүлсэн,

3. Тухайн сэдэвт холбогдох баримтууд, гэрэл зураг зэргийг шинээр илрүүлж судалгааны эргэлтэд оруулсан,

4. Судалгааны үр дүнд үндэслэн төрөөс шашны талаар баримтлах бодлого, үйл ажиллагааны талаар санал дүгнэлт дэвшүүлсэн зэрэг болно.

Энэхүү сэдэвт ажлыг гүйцэтгэх болсон үндсэн шаардлага нь:

Нэгдүгээрт: Монгол Улсын төрөөс шинжлэх ухааны талаар баримтлах бодлого, үндэсний түүх, шашин соёлын судалгааг өргөжүүлэх талаар үндсэн баримт бичигт дэвшүүлсэн заалтуудыг үндэс болгов.

Хоёрдугаарт: ХХ зууны Монголын түүхийн судалгаанд өнөөг хүртэл бараг хөндөгдөөгүй, түүхийн “цагаан толбо” болсоор байгаа сэдэв бол “социалист

байгуулалтын жил”-үүд дэх шашин, сүм хийдийн асуудал болно. Өгүүлэн буй үед нам, төрөөс шашны талаар баримталж байсан бодлого нь “шинжлэх ухааны шашингүйн үзэл”-ийг түгээн дэлгэрүүлэхэд чиглэгдэж, үзэл суртлын төвшинд “социализм, шашин хоёр харшлах бөгөөд нэг нь хөгжих, нөгөө нь мөхөх хувь тавилантай” хэмээн ухуулж байв. Гэвч бодит байдал дээр нийгмийн хүрээнд шашин шүтлэг ил, далд хэлбэрээр явагдаж байсан төдийгүй, 1944-1960 оны хооронд Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт сүм хийд ажиллаж, 1960 оноос хойш Гандантэгчинлин хийдийн үйл ажиллагаа өргөжин тэлсэн, Монголд анх удаа Шашны дээд сургууль байгуулагдсан, “Азийн буддистуудын энх тайвны бага хурал” хэмээх олон улсын байгууллага байгуулагдаж, Монголын лам нар дэлхий дахины энх тайвны төлөө тэмцэлд идэвхтэй оролцон, шашны гадаад харилцаа хөгжсөн, БНМАУ-д Далай лам заларсан зэрэг нь Монголын нийгмийн оюун санааны хүрээнд зохих нөлөө үзүүлж байв. Мөн 1944-1990 оны хоорондох үе бол Монголын шашин, соёлын түүхийн нэгэн өвөрмөц үе шат болно. Ийм учраас 1944-1990 оны хоорондох Монголын нийгэм дэх шашин, сүм хийдийн асуудлыг судлах шаардлагатай байв.

Сэдвийн судлагдсан байдал: Социалист бүтээн байгуулалтын үед шашны эсрэг үзэл суртлын тэмцлийг хүчтэй явуулж байсан хэдий ч шашин нь нийгмийн үзэгдлийн хувьд бодитой оршиж, хүмүүсийн ахуй, ухамсарт нөлөөлсөөр байв. Тийм учраас нийгмийн ухамсрын хүрээнд дэх шашин шүтлэгийн илрэл, түүний шалтгаан нөхцөл болон хүн амыг шашны нөлөөнөөс ангижруулан шинжлэх ухааны мэдлэг эзэмшүүлэх арга зам, нам, төрөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар судалгааны ажил явагдаж байв. Ялангуяа, ШУА-ийн ФСЭХ-гийн Буддын судлалын сектор хөдөлмөрчдийн шашингүйн хүмүүжлийн асуудлаар 1976-1990 оны хооронд 9 удаагийн социологийн судалгааг Улаанбаатар хот болон 11 аймгийн 34 суманд явуулан 6000 гаруй хүнээс социологийн судалгаа аван боловсруулалт хийж, тайлан бичжээ. Эдгээр судалгаагаар тухайн үеийн ард иргэдийн дундах сүсэг бишрэл, түүний илрэх хэлбэр, шинж чанар, шалтгаан нөхцөл, сэдэл болон шашингүйн үзлийн байдал, хэв шинжийн талаар ихээхэн хэмжээний мэдээллийн санг бүрдүүлжээ¹. Ард иргэдийн дунд явуулсан судалгааны үр дүнд социализмын үеийн бурхны шашны

¹ С.Цэдэндамба. “Социализмын үеийн Монгол дахь Буддизмын судалгааны түүхэн тойм”-//”Лам нарын сэтгүүл” 2010 он, 12 сар. №4. Тал 59.

судалгааны эхлэл тавигдаж бие даасан² болон хамтын бүтээлүүд³ гарсан байна. Тэдгээр бүтээлд өгүүлэн буй үеийн Монголын хүн амын ухамсар, ахуй дахь шашин шүтлэгийн илрэл, төлөв байдал, шашны нөлөө, түүний учир шалтгаан, үр дагавар, шашингүйн суртал нэвтрүүлэг, хүмүүжлийн ажлын агуулга, арга хэлбэр, түүнийг боловсронгуй болгох арга замын талаар өгүүлсэн нь өнөөдөр судалгааны хувьд чухал ач холбогдолтой юм. Гэхдээ энэ үеийн судалгаа нь шашны асуудлыг зөвхөн шашингүйн үзлийн онолын үүднээс, шүүмжлэлт байдлаар авч үзэж, тухайн үеийн нэг намын үзэл сурталд захирагдаж байжээ.

Монголын нийгэмд гарсан өөрчлөлттэй уялдан шашны түүхийн судалгаа 1990-ээд оноос шинэ түвшинд гарсан боловч өгүүлэн буй үеийн шашин, сүм хийд болон нийгмийн ухамсар дахь шашны асуудлыг цогц байдлаар тусгайлан судалсан бүтээл өнөөг хүртэл гараагүй байна. Харин төр засгийн шийдвэрээр Мөргөлийн дуганыг нээсэн учир шалтгаан болон Гандантэгчэнлин хийдийн үйл ажиллагаа, хүн амын дундах сүсэг бишрэл болон буддизмын судалгааны талаар товхимол⁴, өгүүлэл, илтгэл⁵ хэвлэгдсэнээс гадна зарим томоохон лам нарын амьдрал үйл хэргийн талаар эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, илтгэлийн эмхэтгэл, намтар дурсамжийн бүтээлүүд хэвлэгдсэн байна⁶. Мөн зарим судлаачдын доктор (Ph.D)-ын зэрэг горилсон нэгэн сэдэвт бүтээлд БНМАУ-ын шашны гадаад харилцаа⁷ болон олон улсын хамтын ажиллагаа, Азийн

² Х.Цэвлээ. Социалист аж төрөх ёс ба шинжлэх ухааны шашингүйн хүмүүжил, Уб.,1980.

Ц.Гомбосүрэн. Орчин үеийн хөрөнгөтний философи дахь шашны зарим чиглэлийг шүүмжлэх нь, Уб.,1986.

³ Социалист байгуулалт ба шинжлэх ухааны шашингүйн материалист үзэл бүрэлдэн тогтсон нь (Шарын шашин дэлгэрсэн улс орнуудад), Уб.,1983, Хөдөлмөрчдийн шашингүйн хүмүүжлийн өнөөгийн асуудал, Уб.,1985. МАХН-ын XIX их хурал, намын үзэл суртлын ажлын зарим асуудал, Уб.,1986 гэх мэт

⁴ Бурхан багшийн 2500 жилийн ой. Эмхэтгэсэн Ш.Сонинбаяр. Уб.,2001. Эрдэм соёлын хүрээлэн Уб.,2008.

⁵ С.Цэдэндамба. “Социализмын үеийн Монгол дахь Буддизмын судалгааны түүхэн тойм”-//”Лам нарын сэтгүүл” 2010 он, 12 сар. №4. Тал 56-60.

Ч.Дамбажав. “Социализмын үеийн Монголын Бурханы шашны үйл ажиллагаа”-//”Лам нарын сэтгүүл” 2010 он, 12 сар. №4. Тал 95-101.

З.Лонжид. “Улаанбаатарт мөргөлийн ганц дуган нээхийг Оросууд зөвшөөрсний учир юу вэ?”-//Харнууд З.Лонжид. Түүх сөхөхүй Уб.,2011, тал 367-376.

⁶ Х.Гаадан-90. Шашин соёл, хэл бичиг судлалын асуудлууд. Эмхэтгэж, эрхлэн хэвлүүлсэн: На.Сүхбаатар, Bibliotheca Oiratica XXXV. Уб.,2014.

Хархөвүүний Гаадан. Мартуузай хэмээн өгүүлсэн элдэв зүйл. Хоёр дахь хэвлэл. Эрхлэн хэвлүүлсэн. На.Сүхбаатар, Уб.,2013 Гандантэгчэнлин хийдийн хамба лам, Чин бишрэлт гавж Н.Эрдэнэпил (Гандантэгчэнлин хийдийн хамба лам, Чин бишрэлт гавж Н.Эрдэнэпилийн мэндэлсний 130 жилийн ойд зориулав). Уб.,2018.

⁷ Ч.Дамбажав. Монголын буддын шашны гадаад харилцааны хөгжилт: Орчин үе. Түүхийн ухаанаар доктор (Ph.D)-ын зэрэг горилсон нэгэн сэдэвт бүтээл. Уб.,2009 он.

Буддистуудын бага хурлын үйл ажиллагааны талаар⁸ судалж, үнэлэлт дүгнэлт өгсөн байна.

Академич Ж.Болдбаатар Монголын Бурхны шашны түүхийн бүтээлдээ социализмын үеийн сүм хийд болон ард иргэдийн дундах сүсэг бишрэлийн талаар товч өгүүлсэн⁹ бол Монгол оронд өрнөсөн өөрчлөн байгуулалтын түүхийн судалгааны бүтээл¹⁰-дээ 1990-ээд оны эхээр шашин, сүм хийдийг сэргээх талаар өрнөсөн үйл явцыг тоймлон авч үзжээ. Мөн социализмын үеийн шашны зүтгэлтнүүдийн намтрыг судалж, шашны түүхэнд гүйцэтгэсэн үүргийг нь үнэлж дүгнэсэн бүтээл өгүүлэл бичжээ¹¹.

Гандантэгчэнлин хийдийн цорж, гавж Г.Диваасамбуу (1928-2015) Гандан хийд дахин сэргэсний 65 жилийн ойд зориулан бичсэн бүтээлдээ 1944-1989 оны гол гол үйл явдлуудыг он цагийн дагуу жил жилээр нь тоймлон бичжээ. Мөн тус хийдийн дацангууд, тэдгээрт хурж байсан хурал номууд болон нандин бурхан шүтээн, хурлын хэрэгслүүд, түүнчлэн хийдийн цэвэрлэгч, галчаас эхлээд лам хуврагууд, албан тушаалтнуудын тухай мэдээлэл оруулсан нь танин мэдэхүйн болоод судалгааны чухал ач холбогдолтой юм¹². Гавж Г.Диваасамбуу Өвөр Монголын Баруун Хуучид хошууны Мэргэн хамбын V дүр Хаянхярваагийн Лувсан (1931-2003)-гийн тухай товхимолдоо Баруун Хуучид хошууны Тимдүвлин хийд 1945 оны сүүлчээр БНМАУ-д нүүдэллэн ирж, удалгүй хамба лам Лувсан хар болсон тул гэсгүй Хайдав хийдийн тэргүүн болж хурал номоо залгуулсаар ирснийг товч бичжээ¹³. Гавж Г.Диваасамбуу эдгээр бүтээлээ бичихдээ өөрийн туулж өнгөрүүлсэн амьдралд тулгуурласнаас гадна сонсож дуулсан аман мэдээ, судалж олсон баримтуудыг ашиглан тухайн үеийн шашны нөхцөл байдлыг товч боловч үнэн бодитой бичиж үлдээснээрээ чухал ач холбогдолтой юм.

Сэдэвт ажлын удирдагч нь сүүлийн жилүүдэд ХХ зууны эхэн үеийн сүм хийд, лам нарын талаар судалгаа явуулж зарим хийд хүрээ, хутагт хувилгаадын

⁸ J.Lkhagvademchig. Double Headed Mongolian Buddhism: A Historical and Anthropological Study on Identity Politics Inside the Mongolian Buddhist Institution6 (2018) pp.81-106.

⁹ Ж.Болдбаатар. “Социализмын үеийн сүм хийд, сүсэг бишрэл”-//Ж.Болдбаатар. Монголын Бурханы шашны лам хувраг Уб.,2018, тал 247-257.

¹⁰ Ж.Болдбаатар. Монголын “перестройка”-гийн (өөрчлөн байгуулалт) түүхийн судалгаа. Улс төрийн түүх (1980-аад оны эхнээс 1992 он). Уб.,2017.

¹¹ Ж.Болдбаатар. “Номч мэргэн гавж Самаагийн Гомбожав”-//”Билиг оюуны ойллого-II (2016, 2017 онд бичсэн илтгэл, өгүүлэл, ярилцлага). Эмхэтгэн хэвлүүлсэн: Б.Дэлгэрмаа. Уб.,2018, тал 207-223.

Ж.Болдбаатар. “Хархүүгийн Гаадан багштан”-//”Билиг оюуны ойллого-II (2016, 2017 онд бичсэн илтгэл, өгүүлэл, ярилцлага). Эмхэтгэн хэвлүүлсэн: Б.Дэлгэрмаа. Уб.,2018, тал 224-237.

¹² Г.Диваасамбуу. Гандантэгчинлин хийд дахин сэргэсэн түүх. Уб.,2009. 130 тал.

¹³ Гаржидын Диваасамбуу. Баруун Хуучид хошууны Мэргэн хамбын түүх. Уб.,2003, 39 тал.

тухай ном бичиж хэвлүүлсэн¹⁴-ээс гадна социализмын үеийн шашны асуудлаар олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлж¹⁵, Баргын түүх, угсаатны зүйн бүтээлдээ Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Гандансамданлин хийдийн тухай бичиж хэвлүүлсэн¹⁶ байна.

Судлагдсан байдалд үндэслэн дүгнэхэд “социализм”-ын үеийн Монголын Буддын шашны судалгааны эхлэл нэгэнт тавигдсан тул уг судалгааг эрчимжүүлэн шинэ шатанд гаргах шаардлагатай байсан бөгөөд энэ нь энэхүү сэдэвт ажлыг явуулах бас нэгэн үндэслэл болсон юм.

“БНМАУ: Социализм ба Буддизм” (ШуСс_2019/59) суурь судалгааны төслийн даалгаварт:

1. “БНМАУ: Социализм ба Бурханы шашин” (20 х.х) нэгэн сэдэвт бүтээл
2. “БНМАУ дахь шашин, сүм хийд, лам нар: Аман түүхийн судалгаа” (15-20 х.х)
3. Эрдэм шинжилгээний илтгэл болон өгүүлэл 5-аас доошгүй (3-5 х.х)-г бичиж нийтлүүлэхээр тусгасан болно.

Суурь судалгааны төслийн зардал нь эрдэм шинжилгээний ажлын зардал, хөдөө орон нутгийн архивт томилолтоор ажиллах, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, төсөлд гэрээгээр оролцогчдын цалин, судалгааны ажлын үр дүнг хэвлэн нийтлэх, сэдэвт ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт, магадалгаа хийлгэх зэрэг зардлаас бүрдсэн бөгөөд нийтдээ 33,800,000 төгрөгийн санхүүжилт хийхээр гэрээнд тусгаж, санхүүжилтийг бүрэн авч гэрээнд

¹⁴ Г.Мягмарсамбуу. Монголын шашин, төрийн нэрт зүтгэлтэн Егүзэр хутагт Жамсранжавын Галсандаш (1870-1930). УБ.,2014. 22 х.х

Г.Мягмарсамбуу. Чингис хааны тахилгын сүм. УБ.,2015. 12 х.х.

Г.Мягмарсамбуу. Богд хааны тогтоосон шашин, төрийн ёс. УБ.,2015. 10,8 х.х.

Г.Мягмарсамбуу, Ч.Батдорж. Зая Бандида хутагтын хүрээний хувилгаан, гүж лам Батсуурь (1895-1925). УБ.,2018. 14,1 х.х.

¹⁵ Г.Мягмарсамбуу. “Баргын Гандансамданлин хийдийн тухай”-//“Олон улсын монголч эрдэмтдийн X их хурлын илтгэлүүд”. V боть. Монголын тусгаар тогтнол, хувьсгал. УБ.,2013, тал 63-70.

Г.Мягмарсамбуу. “БНМАУ-ын социалист байгуулалтын эхний жилүүд дэх шашин, сүм хийдийн төлөв байдал”-//“БНМАУ-ын бүтээн байгуулалтын жилүүд ба Ю.Цэдэнбал” (Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл) УБ.,2017, тал 34-49.

Г.Мягмарсамбуу. “Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн түүхэнд холбогдох нэгэн баримт”-// “Гандантэгчэнлин хийдийн хамба лам, Чин бишрэлт гавж Н.Эрдэнэпил” (Гандантэгчэнлин хийдийн Хамба лам, Чин бишрэлт гавж Н.Эрдэнэпилийн мэндэлсний 130 жилийн ойд зориулав) УБ.,2018, тал 90-101.

Г.Мягмарсамбуу. “Монгол, Зөвлөлтийн шашны асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын харилцаа:Эхлэл, үр дүн”-//“БНМАУ-ын бүтээн байгуулалт: Ололт, амжилт, сургамж” (1954-1980-аад оны сүүлч)

Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Эмхэтгэсэн: Б.Пунсалдулам, Ц.Энхжаргал, УБ.,2020, тал 132-148.

¹⁶ Г.Мягмарсамбуу. Баргын түүх, угсаатны зүй. Дэд боть. Баргын угсаатны зүй. УБ.,2018. 28 х.х. Тал 204-17.

заасны дагуу зарцуулав. Үүнд, 2019 онд 12,000,000 төг, 2020 онд 15,500,000 төг, 2021-2022 онд 16,500,000 төгрөгийн санхүүжилт хийсэн байна.

Суурь судалгааны төслийн ажил гэрээнд зааснаар 2021 онд дуусах байсан боловч цар тахлын нөхцөл байдалтай уялдан хугацааг нэг жилээр сунгаж, 2022 онд дуусган үр дүнг захиалагчид хүлээлгэн өгч байна.

Тайлангийн үндсэн хэсэг

Энэхүү судалгааны ажлын хүрээнд сэдэвт холбогдох эх сурвалжуудыг нягтлан судлахад гол анхаарлаа хандуулан юуны түрүүнд МУУТА-ын ТБА, Монгол Улсын Засгийн газрын архив, ТЕГ-ын Тусгай архивт судалгаа явуулав. Мөн доктор (Ph.D), профессор Г.Мягмарсамбуу 2019 онд Сүхбаатар, Дорноговь аймгийн, 2020, 2022 онд Архангай аймгийн Төрийн архивуудад томилолтоор ажиллаж судалгаа хийв.

Суурь судалгааны сэдэвт ажлыг гүйцэтгэхдээ судалгааны дараах арга зарчмыг баримтлав. Үүнд:

Нэгдүгээрт: Марксист түүх бичлэг ноёрхож байх үеэс уламжлагдан ирсэн үзэл сурталч, догматик байдлаар түүхэнд хандах, түүх бичлэгт цаг үеийн үзэл суртлын байдалд нийцүүлэн цагаан толбо үлдээх, түүхийг эзэнгүйдүүлэх байдлыг халж, тухайн түүхэн тодорхой нөхцөлд, хүмүүсийн оюун билгийн түвшинд нь асуудлыг “түүхэн зарчим”-ын үүднээс шинжлэн судлах арга зүйн шинэлэг хандлагыг баримтлав.

Хоёрдугаарт: Монголын түүх судлалд 1990-ээд оноос ноёрхож байсан түүхийг эзэнгүйдүүлэх явдлаас зайлсхийж, түүхийг хүн судлалын үүднээс бичдэг Өрнөдийн түүх судлалын арга зарчмыг баримтлан социализмын үеийн шашны түүхэнд гол үүрэг гүйцэтгэсэн хүмүүсийг тодруулан үнэлж дүгнэхийг оролдов. Үүнд, нам, төрийн тэргүүн Ю.Цэдэнбал болон Гандан хийдийн хамба лам нар болон ШХЭЗ-ийг тэргүүлж байсан хүмүүс зэргийг дурдаж болно.

Гуравдугаарт: Монголын түүхийн тодорхой үеийг судлахдаа нэг бол дотоод хүчин зүйлийг хэт үнэлдэг, эсвэл гадаад хүчин зүйлийг хэт шүтдэг “туйлшрах” хандлагаас зайлсхийж, түүхэн үзэгдэл үйл явдалд нөлөөлсөн дотоод, гадаад хүчин зүйлийг тэнцвэртэй авч үзэхийг эрмэлзэв.

Дөрөвдүгээрт: Түүхэн зарчмын гол үндэс болсон түүхэн баримт нотолгоонд үндэслэх аргыг гол болгож, урьд өмнө судалгааны эргэлтэнд ороогүй шинэ баримтуудыг илрүүлэн судалгааны эргэлтэд оруулах, аливаа түүхэн үзэгдэл үйл явдлыг баримтад тулгуурлан үнэлж дүгнэх аргыг баримтлав.

Судалгааныхаа завсрын үр дүнгээр “БНМАУ: Буддын шашин, сүм хийдийн асуудал” (1944-1990) сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2020 оны 11 дүгээр сарын 6-нд зохион байгуулав. Хуралд МУИС, МУБИС, ОУДС, МҮИС, МБШТөв Гандантэгчинлэн хийдийн Эрдэм соёлын хүрээлэн, ШДС болон ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэн, БНЧУ-ын Масарикийн Их

Сургуулийн Ази судлалын төвийн эрдэмтэд оролцож, 16 илтгэл хэлэлцүүлэв. Хуралд ОУМСХ-ны Ерөнхийлөгч, Унгар улсын Өвтөш Лораандын нэрэмжит их сургуулийн Монгол ба төв Ази судлалын тэнхимийн эрхлэгч, монголч эрдэмтэн, доктор, профессор Бирталан Агнэш мэндчилгээ дэвшүүлэв. Хуралд хэлэлцүүлсэн илтгэлүүдэд БНМАУ-ын “социалист байгуулалт”-ын үед нам төрөөс бурхны шашны талаар баримталсан бодлого, түүний хэрэгжилт, шашны чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа, БНМАУ дахь шашингүйн үзэл, шашин шүтлэгийг хязгаарлах үйл ажиллагаа, шашны зүтгэлтнүүд, номын мэргэдийн бүтээл туурвил, намтар судлалын тухайд шинэ сонирхолтой баримт, санал дүгнэлтүүдийг дэвшүүлсэн нь судалгааны хувьд чухал ач холбогдолтой болсон юм. Хурлын үеэр судлаачид тус судалгааны ажлыг цаашид улам өргөжүүлэн, шинэлэг цогц байдлаар судлах шаардлагатайг онцлон тэмдэглэж байсан бөгөөд энэхүү хурал нь тухайн сэдвээр зохион байгуулсан анхны эрдэм шинжилгээний хурал болсон юм. Тус хурал нь 1944-1992 оны Монголын шашин, сүм хийдийн түүхээр судалгаа явуулдаг дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдын судалгааны үр дүнг харилцан сонсож хэлэлцэх, хамтын ажиллагааг нь хөгжүүлэхэд тус дэм болох, социализмын үеийн шашны асуудалд судлаач, сонирхогчдын анхаарлыг хандуулахад чухал түлхэц болсон юм. Хурлын илтгэлүүдийг 2021 оны эхээр эмхэтгэн хэвлүүлж олны хүртээл болгосон нь энэхүү төслийн ажлын нэг гол үр дүн болсон юм. Мөн судалгааны завсрын үр дүнгээр 2 өгүүлэл, 5 илтгэл бичиж хэвлүүлэн нийтийн хүртээл болгов.

Судалгааны гол үр дүн: Суурь судалгааны үр дүнгээр “БНМАУ: Социализм ба Буддизм” (1944-1992) нэгэн сэдэвт бүтээлийг бичиж 2022 оны долдугаар сард хэвлүүлэв. Энэхүү бүтээлийг туурвихдаа нам, төрөөс шашны талаар баримталсан бодлогыг нийгмийн ухамсар, шашны бодит оршин ахуй, гадаад хүчин зүйлтэй нь харьцуулан судлахыг зорьсон бөгөөд юуны түрүүнд,

- Нам, төрөөс шашны талаар баримталсан бодлого хийгээд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Шашны төлөөлөгч, ШХЭЗ-ийн үйл ажиллагаа,
- Сүм хийдүүдийн үйл ажиллагаа, цар хүрээ, нөлөө,
- Тухайн үеийн лам нарын үзэл бодол, амьдрал ахуй хийгээд ШДС байгуулагдаж, лам нарыг бэлтгэж байсан асуудал,
- Нийгмийн ухамсрын хүрээн дэх шашин шүтлэгийн төлөв байдал, шашны нөлөөллийн эсрэг явуулсан үйл ажиллагаа,
- Шашны гадаад харилцаа буюу гадаад хүчин зүйл зэрэг асуудалд гол анхаарлаа хандуулав. Өөрөөр хэлбэл, Буддын шашин, сүм хийдийн асуудлыг

тухайн үеийн бодит оршин ахуйд нь, гагцхүү түүхэн баримт мэдээнд тулгуурлан нам, төрийн бодлого-нийгмийн ахуй, ухамсар-сүм хийд, лам нар хийгээд гадаад хүчин зүйлийн хүрээнд судлахыг хичээв. Үүний тулд судлагдахуунаа ямар нэгэн онол, бодлогын үүднээс харж тайлбарлах бус гагцхүү баримт нотолгоонд тулгуурлан, түүхэн судалгааны аргаар бодит байдлыг нэхэн тодруулах зарчмыг баримталсан болно. Мөн бүтээлийг туурвихдаа дээр дурдсан архивуудын баримт болон судалгааны бүтээлүүд, түүнчлэн аман түүхийн мэдээ, түүхэн гэрэл зураг, баримтат кино, тогтмол хэвлэлийн өгүүлэл болон зарим хувь хүмүүст хадгалагдаж байгаа шашин соёлын өв зэрэг олон талын баримт, мэдээллийг ашиглав. Архивын баримтууд нь ихэвчлэн анх удаа судалгааны эргэлтэд орж буй шинэ баримтууд юм.

“Социализм”-ын үеийн шашны асуудлыг анх удаа өргөн хүрээнд судалсан энэхүү нэгэн сэдэвт зохиол нь удиртгал, 3 бүлэг, 13 зүйл, дүгнэлт, хавсралт, нэрийн хэлхээнээс бүрдэнэ. Удиртгалд, Монголд бурхны шашин дэлгэрсэн түүхийг товч дурдаж, сэдвийн судлагдсан байдал, судалгааны зорилго, зорилтыг тодорхойлов.

Нэгдүгээр бүлэгт, 1944-1959 онд төрөөс шашны талаар баримталсан бодлого хийгээд Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байсан хийдүүдийн талаар өгүүлэв.

Хоёрдугаар бүлэгт, 1960-1980-аад оны сүүлч хүртэлх хугацаанд төрөөс шашны талаар баримталсан бодлого, үйл ажиллагаа, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Шашны хэрэг эрхлэх зөвлөл болон Гандантэгчинлин хийдийн түүхийг бичив.

Гуравдугаар бүлэгт, өгүүлэн буй үеийн шашны гадаад харилцааны үүсэл, хөгжил болон 1980-аад оны сүүлчээр өрнөсөн өөрчлөн байгуулалтын нөлөөгөөр үндэсний шашин соёлын дэлгэрэлт шинэ шатанд гарсан үйл явцыг товч өгүүлэв.

Хавсралтад, Дорнод аймгийн Хэрлэнбаян сумын Түвдэнпэлжээлин хийдийн хурлын бүрээний ян ег, мөн аймгийн Халх гол сумын харьяат, МУБИС-ийн багш, доктор (Ph.D) Ч.Байгалмаад хадгалагдаж байгаа ая дангийн судар болон Сүхбаатар аймгийн музейд байгаа цорж Д.Жамсран (1919-1978)-гийн хэрэглэж байсан тахилын хэрэгслийн зураг, товч тайлбарыг оруулав. Эдгээр нь анх удаа хэвлэгдэж, судалгааны эргэлтэд орж байгаа юм.

Бүтээлийг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Монгол Улсын Ардын багш, академич Ж.Болдбаатар, “Зүүн Хүрээ Дашчойлин” хийдийн хамба, Монгол Улсын Соёлын

гавьяат зүтгэлтэн, доктор (Ph.D), Ч.Дамбажав нар редакторлаж, ШУА-ийн Философийн хүрээлэнгийн захирал, философийн ухааны доктор (Ph.D), профессор Б.Пүрэвсүрэн, МУИС-ийн ШУС-ийн Антропологи-археологийн тэнхимийн багш, доктор (Ph.D) Ж.Лхагвадэмчиг нар дүгнэлт гаргасны үндсэн дээр ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж хэвлүүлэв. Энэхүү бүтээл нь БНМАУ-д “социализм байгуулах” үеийн шашны түүхээр гарч буй анхны бие даасан бүтээл бөгөөд бүх шатны сургалт, эрдэм шинжилгээний ажилд ашиглах боломжтой юм.

Социализмын үеийн шашны асуудлыг судлахад архивын баримтаас гадна аман түүхийн мэдээ чухал ач холбогдолтой юм. Аман түүх нь архивын баримтад тэмдэглээгүй, хүмүүсийн ой санамжид үлдсэн мэдээллийг агуулж байдаг тул тухайн үеийн нийгмийн хамгийн үнэн дүр төрхийг харуулах, өөрөөр хэлбэл, “далд түүх”-ийг илрүүлдэг онцлогтой. Тийм учраас бид социализмын үеийн шашны асуудлыг нягтлан судлахдаа архивын баримтаас гадна аман түүхийн мэдээ баримтыг ашиглахыг эрмэлзэж, цөөнгүй хүнээс яриа, дурсамж авсан бөгөөд тэдгээрээс 16 хүний дурсамж, яриаг эмхэтгэн “БНМАУ: Социализм ба Бурхны шашин” (Аман түүх) бүтээлийг хэвлүүлэв. Энэхүү бүтээлд аман түүхийг нь багтаасан хүмүүсийг ажил мэргэжлийн хувьд авч үзвэл нам, төрийн зүтгэлтэн 3 хүн, ШДС-ийн төгсөгч, өдгөө шашин номын мэргэд болох 5 хүн, тухайн нийгмийн үед өвөө, аав болон өвгөн лам нарын дэргэд өсөж, хүмүүжсэн 8 хүн байна. Түүнээс гадна “Ю.Цэдэнбал” академи-ийн архиваас нам, төрийн тэргүүн Ю.Цэдэнбал шашинд хэрхэн ханддаг байсан тухай зарим хүмүүсийн дурсамжийг нэмж оруулав. Энэхүү бүтээлийг тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), профессор Н.Хишигт редакторлаж, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр хэвлүүлэв.

Судалгааны үр дүнг хэлэлцүүлсэн байдал: Судалгааны үр дүнд бичсэн бүтээлүүдийг Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Ойрх үеийн түүхийн салбар болон Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн хэвлэж байсныг дээр дурдсан билээ. Мөн доктор (Ph.D), профессор Г.Мягмарсамбуу 2022 оны 12 дугаар сарын 17-18-нд Япон улсын Угсаатан судлалын музейд Япон улсын Шинжлэх ухааныг дэмжих нийгэмлэгийн ивээн тэтгэлгээр зохион байгуулсан “Орчин үеийн Монгол дахь Буддын шашны үйл явц ба хутагт хувилгаад” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд “Социализмын үеийн Монголын Буддизм: Судалгаа, үр

дүн” сэдэвт илтгэл хэлэлцүүлэв. Энэхүү илтгэлд “БНМАУ: Социализм ба бурхны шашин” (ШуСс_2019/59) сэдэвт суурь судалгааны төслийн ажил, судалгааны гол үр дүнг хэлэлцүүлэв. Мөн 2023 оны 1 дүгээр сарын 30-нд суурь судалгааны төслийн үр дүнд хэвлэгдсэн “БНМАУ: Социализм ба Буддизм” (1944-1992), “БНМАУ: Социализм ба Бурхны шашин” (Аман түүх) бүтээлийн нээлт, шүүмж хэлэлцүүлгийг зохион байгуулав. Энэхүү шүүмж хэлэлцүүлэгт Түүхийн ухааны доктор (Ph.D), профессор З.Лонжид, МУИС-ийн ШУС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D) С.Янжинсүрэн нар “БНМАУ: Социализм ба Буддизм” (1944-1992) нэгэн сэдэвт бүтээлийн тухай, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Нийгэм соёлын хүн судлалын судалгааны салбарын эрхлэгч, магистр Г.Бямбарагчаа “БНМАУ: Социализм ба Бурхны шашин” (Аман түүх) бүтээлийн тухай тус тус шүүмж хийж, оролцогчид эдгээр бүтээлийн тухай саналаа хэлсэн нь суурь судалгааны ажлын үр дүнг олон нийтэд хүргэх, судалгааны үр дүнг шүүн хэлэлцэж цаашдын судалгааны чиглэлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой болов.

ДҮГНЭЛТ

Төслийн судалгааны үр дүнд нэгэн сэдэвт бүтээл 1, аман түүхийн бүтээл 1, олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 1, илтгэл, өгүүлэл 7-г бичиж хэвлүүлэн нийтийн хүртээл болгов. Энэхүү үзүүлэлт нь гэрээнд заасан сэдэвт ажлын эцсийн үр дүнг бүрэн хангаж байгаа юм.

Сэдэвт ажлын шинжлэх ухаан, нийгмийн үндсэн ач холбогдол нь:

- XX зууны Монголын түүхийн зангилаа асуудлын нэг болох социалист бүтээн байгуулалтын жилүүд дэх шашны асуудлыг анх удаа шинэлэг, цогц байдлаар гаргаж тавьсан,

- Монголын түүхийн суурь судалгааны төвшинг дээшлүүлж, тухайн сэдвээр шинэ мэдлэг буй болгосон.

-Монголын орчин үеийн түүхийн судалгааг шин агуулга, чиглэлээр хөгжүүлсэн.

-Цаашид шашны талаар төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулахад чухал түлхэц болж, түүхэн сургамжийг нээн харуулсан.

-Судалгааны үр дүнгээр гарсан бүтээлүүдийг бүх шатны сургалт, судалгаа, танин мэдэхүйн үйл ажиллагаанд ашиглах боломжтой юм.

Цаашид энэхүү судалгааны ажлыг үргэлжлүүлэх нь чухал байгаа бөгөөд цаашдын судалгааны чиг хандлагын талаар 2023 оны 1 дүгээр сарын 30-нд зохион байгуулсан шүүмж хэлэлцүүлэг дээр тодорхой саналууд гарсан юм. Тэдгээр санал шүүмжийг харгалзан үзэж бид юуны түрүүнд баримт бичгийн эмхэтгэл гаргах шаардлагатай байна. Түүнчлэн “социализмын үеийн Монголын шашин, сүм хийдийн асуудал”-ын хүрээнд 1921-1930-аад оны сүүлч хүртэлх түүхийг хамруулан авч үзэж болох юм. Тийм учраас цаашид энэ үеийн шашин, сүм хийдийн асуудлаар суурь судалгааны төсөл боловсруулан хэрэгжүүлэх нь чухал байна. Ингэснээр Монголд хувьсгалт үзэл санаа, нэг намын үзэл суртал ноёрхож байсан үеийн шашин, сүм хийдийн асуудлыг цогц байдлаар авч үзэх боломж бүрдэх талтай.

ШУТС-аас 2022 оны 11 дүгээр сарын 2-нд төслийн ажлын явцад мониторинг хийсэн болно.

Суурь судалгааны сэдэвт ажлын үр дүнгээр хэвлэгдсэн бүтээлийн номзүй

Нэгэн сэдэвт бүтээл

Г.Мягмарсамбуу. “БНМАУ: Социализм ба Буддизм” (1944-1992). “Соёмбо Принтинг”. УБ.,2021. 314 тал

Аман түүхийн бүтээл

“БНМАУ: Социализм ба Бурхны шашин” (Аман түүх). Эрхэлсэн: Н.Мягмар, Г.Мягмарсамбуу. “Соёмбо Принтинг”. УБ.,2022. 224 тал

Эмхэтгэл


“БНМАУ: Буддын шашин, сүм хийдийн асуудал” (1944-1990 он). Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Эмхэтгэсэн: Г.Цэрэнсугар. “Соёмбо Принтинг”. УБ.,2021. 220 тал

Илтгэл, өгүүлэл

1. Г.Мягмарсамбуу. “Социализмын эхний жилүүд дэх шашин, сүм хийдийн асуудал” (1940-1960 он)-//“Түүхийн судлал” сэтгүүл. Tomus XLVIII, Fasc-1-29. УБ.,2019, тал 307-320.
2. Г.Мягмарсамбуу. “Гандан хийдийг сэргээсэн түүхэнд холбогдох архивын зарим баримтын тухай”-//“Монголын архив” Эрдэм шинжилгээ, арга зүйн сэтгүүл. 2019 №01/18/, тал 22-29 (Энэхүү сэтгүүл нь 2020 онд хэвлэгдсэн бөгөөд өмнөх оны дугаарыг нөхөж гаргасан учраас хэвлэгдсэн огноог 2019 гэж тавьсан байна).
3. Г.Мягмарсамбуу. “Монгол, Зөвлөлтийн шашны асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын харилцаа: Эхлэл, үр дүн”-//“БНМАУ-ын бүтээн байгуулалт: Ололт, амжилт, сургамж” (1954-1980-аад оны сүүлч) Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Эмхэтгэсэн: Б.Пунсалдулам, Ц.Энхжаргал, УБ.,2020, тал 132-148.
4. Г.Мягмарсамбуу. “БНМАУ: Буддын шашин, сүм хийдийн асуудал”-//“БНМАУ: Буддын шашин, сүм хийдийн асуудал” (1944-1990). Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Эмхэтгэсэн: Г.Цэрэнсугар. УБ.,2021, тал 13-32.

5. Н.Мягмар. “Нийгмийн ухамсар дахь шашин шүтлэгийн илрэл, түүний эсрэг тэмцсэн нь” (Төв аймгийн жишээн дээр)-//”БНМАУ: Буддын шашин, сүм хийдийн асуудал” (1944-1990). Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Эмхэтгэсэн: Г.Цэрэнсугар. Уб.,2021, тал 111-122
6. Г.Цэрэнсугар. “Гандантэгчинлэн хийдийн их хамба, номч мэргэн гавж С.Гомбожавын амьдрал, үйл хэрэг”-)-//”БНМАУ: Буддын шашин, сүм хийдийн асуудал” (1944-1990). Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Эмхэтгэсэн: Г.Цэрэнсугар. Уб.,2021, тал 111-122
7. Г.Мягмарсамбуу. “Социализмын үеийн Монголын Буддизм: Судалгаа, үр дүн” сэдэвт илтгэл. Япон улсын Угсаатан судлалын музейд 2022 оны 12 дугаар сарын 17-18-нд зохион байгуулсан “Орчин үеийн Монгол дахь Буддын шашны үйл явц ба хутагт хувилгаад” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл.


Төслийн хүрээнд хэвлүүлсэн бүтээл



Нэгэн сэдэвт бүтээл

Г.Мягмарсамбуу. “БНМАУ: Социализм ба Буддизм” (1944-1992). УБ.,2021. 18,3 х.х.


“Соёмбо Принтинг” ХХК-д хэвлэв.



Аман түүхийн бүтээл

“БНМАУ: Социализм ба Бурхны шашин” (Аман түүх). Эрхэлсэн: Н.Мягмар,

Г.Мягмарсамбуу. УБ.,2022. 18,67 х.х. “Соёмбо Принтинг” ХХК-д хэвлэв.



Эмхэтгэл

”БНМАУ: Буддын шашин, сүм хийдийн асуудал” (1944-1990 он). Олон улсын эрдэм

шинжилгээний хурлын эмхэтгэл. Эмхэтгэсэн:

Г.Цэрэнсугар. УБ.,2021. 18,3 х.х. “Соёмбо Принтинг” ХХК-д хэвлэв.

Эрдэм шинжилгээний илтгэл

1. Г.Мягмарсамбуу. “Монгол, Зөвлөлтийн шашны асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын харилцаа: Эхлэл, үр дүн”-//”БНМАУ-ын бүтээн байгуулалт: Ололт, амжилт, сургамж” (1954-1980-аад оны сүүлч) Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Эмхэтгэсэн: Б.Пунсалдулам, Ц.Энхжаргал, Уб.,2020, тал 132-148.
2. Г.Мягмарсамбуу. “БНМАУ: Буддын шашин, сүм хийдийн асуудал”- //”БНМАУ: Буддын шашин, сүм хийдийн асуудал” (1944-1990). Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Эмхэтгэсэн: Г.Цэрэнсугар. Уб.,2021, тал 13-32.
3. Н.Мягмар. “Нийгмийн ухамсар дахь шашин шүтлэгийн илрэл, түүний эсрэг тэмцсэн нь” (Төв аймгийн жишээн дээр)-//”БНМАУ: Буддын шашин, сүм хийдийн асуудал” (1944-1990). Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Эмхэтгэсэн: Г.Цэрэнсугар. Уб.,2021, тал 111-122
4. Г.Цэрэнсугар. “Гандантэгчинлэн хийдийн их хамба, номч мэргэн гавж С.Гомбожавын амьдрал, үйл хэрэг”-)-//”БНМАУ: Буддын шашин, сүм хийдийн асуудал” (1944-1990). Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Эмхэтгэсэн: Г.Цэрэнсугар. Уб.,2021, тал 111-122

Эрдэм шинжилгээний өгүүлэл